

ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

П.Алтанбат

ДХИС-ийн Удирдлагын академийн 8023 дугаар дамжааны суралцагч, ахмад

Товч агуулга: Энэхүү илтгэлээр хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг хангаж буй эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалалд нөлөөлж буй шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж асуудлыг шийдвэрлэх ажилд тус дэм болохыг зорилоо.

Түлхүүр үг: Хорихоос өөр төрлийн ял, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал, эрүүгийн ял хариуцсан шийдвэр гүйцэтгэгч.

Abstract: The article is devoted to will soon begin to enforce the restraining punishment of restriction on freedom of travel, implementing and improving critical issues in implementing and improving the use of electronic bracelet used by foreign countries and highlighting some of the issues that need to be addressed.

Keywords: Electronic bracelet, convict, punishment, electronic monitoring, punishment of restriction on freedom of travel.

Оршил

Орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь анх 1921 онд байгуулагдсан цаг үеэс хойш 100 гаруй жилийн хугацаанд төрийн эрүүгийн ялын хэрэгжилтийг хангах, ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хамаарах 7 удаагийн (1931, 1966, 1981, 1993, 1996, 2002, 2017) онуудыг хуулийг батлан хэрэгжүүлж иржээ¹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “...Анх зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагааг гардан гүйцэтгэж ирсэн хэдий ч өнөөдөр

иргэн, захиргаа, зөрчил, эрүүгийн хэргийн талаарх бүхий л төрийн шийдвэрийг гүйцэтгэдэг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон хөгжиж байна...” гэсэн Хууль зүйн доктор, бригадын генерал Д.Дамдинцэрэнгийн гаргасан тодорхойлолттой судлаачийн зүгээс санал нэг байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1-т “... хуулийн байгууллагуудын үйл

¹ Д.Дамдинцэрэн. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 9 дэх тал.

ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх, эрх зүйн орчинг цогцоор бүрдүүлнэ...”, 5.4.10-т “...хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон телекамерийн хяналтын системийг нэвтрүүлэх...” гэж тус тус заасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн боловсруулах¹ цаг үеийн шаардлагыг бий болгож, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг илүү өргөн хүрээнд хүргэхийг хирээр бүтэц, орон тоо ажлын ачааллыг ч ман адил нэмэгдүүлсэн гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Нэг. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 онд батлагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлснээс 2002 оны Эрүүгийн хууль хүчингүй болсонд тооцогдсон бөгөөд шинээр батлагдсан эрүүгийн хуульд “...торгох, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах...” ялыг хорихоос өөр төрлийн ял² гэж хуульчилсан.

Үндсэндээ шинэчлэн батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан 5 төрлийн ялаас хорихоос өөр төрлийн 4 төрлийн ялыг хэрэгжилтийг “...хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч буюу эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нар хэрэгжилтийг хангахаар зохицуулсан...”³ гэж ойлгож болох юм.

Судлаачийн зүгээс эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн гол хүчин зүйлийг нээн илрүүлэх үүднээс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Эрүүгийн хууль болон шинэчлэн батлагдсан 2017 оны эрүүгийн хуульд харьцуулалт хийснийг тоймлон энд хүргэе.

Өмнө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны эрүүгийн хуульд нийт 858 гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож, “...торгох, хорих, албадан ажил хийлгэх, баривчлах, цаазаар авах ялыг үндсэн ялаар, “тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялаар, эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай

¹ Д.Дамдинцэрэн. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 9 дэх тал.

² Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 180 дахь тал.

³ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 180 дахь тал.

оногдуулах...”-аар тус тус зохицуулсан байна¹. Үүнд:

- Хорих ялыг бусад төрлийн ялаас сонгох бололцоогүй буюу дангаар 467 гэмт үйлдэлд;

- Торгох ялыг хорих болон бусад төрлийн ялаас сонгох бололцоотойгоор 232 гэмт хэрэгт;

- Тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 54 гэмт хэрэгт бусад төрлийн ялаас сонгож оногдуулахаар;


- Баривчлах ялыг 97 гэмт хэрэгт;

- Цаазаар авах ялыг 7 гэмт хэрэгт;

- Албадан ажил хийлгэх ялыг 71 гэмт хэрэгт бусад төрлийн ялаас сонгох боломжтойгоор;

- Эрх хасах ялыг хорих болон хорихоос бусад төрлийн ялаас сонгох боломжтойгоор 56 гэмт үйлдэлд оногдуулахаар тус тус зохицуулсан байна.

Зураг 1. 2002 оны эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь.



Монгол Улсын Их Хурлаар шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-д нийт 1088 гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож, “...хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах ял, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах...” гэсэн ялын төрлүүдийг “...үндсэн ба нэмэгдэл...” ялын чанартай оногдуулахаар заасан. Үүнд:

- Хорих ялыг бусад төрлийн ялаас сонгох бололцоогүйгээр буюу

дангаар 469 гэмт үйлдэлд оногдуулахаар;

- Торгох ялыг хорих болон хорихоос бусад төрлийн ялаас сонгох бололцоотойгоор 267 гэмт хэрэгт оногдуулахаар;

- Зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 гэмт хэрэгт бусад төрлийн ялаас сонгож оногдуулахаар;


- Эрх хасах ялыг хорих болон бусад төрлийн ялаас сонгох боломжтойгоор 44 гэмт үйлдэлд

¹ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны

эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 180 дахь тал.

оногдуулахаар тус тус зохицуулсан байна.

Зураг 2. Шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-д тусгасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь. (Эрүүгийн хууль 2015 он.)



Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар тогтоосон бөгөөд хөнгөн гэмт хэрэгт -121, хүнд гэмт хэрэгт -119 тохиололд оногдуулахаар хуульчилсан байна. Үүнд:

- Зорчих эрхийг хязгаарлах ял эсхүл хорих ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 176 гэмт хэрэгт;
- Зорчих эрхийг хязгаарлах ял, торгох ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 153 гэмт хэрэгт;
- Зорчих эрхийг хязгаарлах ял, торгох эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ялын аль нэгийг сонгож 48 заалтад оногдуулахаар тогтоожээ.

Хүснэгт 3. 2017 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулах гэмт хэргийн төрөл, зүйл анги, нийт оногдуулах тоо

Д	Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүлгийн нэр, гэмт хэргийн төрөл		Зүйл анги, нийт оногдуулах тоо	
11	Аравдугаар бүлэг	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10.5.1, 10.6.1	2
22	Арван нэгдүгээр бүлэг	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11.2.1, 11.3.1 11.3.2, 11.4.1, 11.4.2.2, 11.4.2.3, 11.5.1,11.5.2, 11.6.1, 11.6.2, 11.7.1-1.3, 11.7.2-2.3,	17
33	Арван хоёрдугаар бүлэг	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12.3, 12.5.1, 12.5.2.1, 12.5.2.2, 12.6.1, 12.6.2	6
44	Арван гуравдугаар бүлэг	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	13.4,13.5.1, 13.5.2.1, 13.5.2.2, 13.5.3.1, 13.5.3.2, 13.6, 13.7.1, 13.7.2, 13.8.1, 13.8.3, 13.9.1, 13.9.2, 13.10.1, 13.10.2.1, 13.10.2.2, 13.11.1, 13.11.2, 13.12.1, 13.13.1, 13.14.1	21

55	Арван дөрөвдүгээр бүлэг	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	14.1.1, 14.2.1, 14.2.2, 14.2.3, 14.3.1, 14.4.1, 14.4.2, 14.5.1, 14.5.2.1, 14.5.2.2, 14.5.2.3, 14.6.1, 14.6.2, 14.7.1, 14.8.1, 14.8.2	17
66	Арван тавдугаар бүлэг	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	15.1.1, 15.1.2, 15.1.3, 15.2.1, 15.5.2, 15.6.1, 15.6.2	7
77	Арван зургадугаар бүлэг	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	16.1.1, 16.2.1, 16.3.1, 16.4.1, 16.5.1, 16.7.1, 16.7.2, 16.8.1, 16.9.1, 16.10.1, 16.11.1, 16.11.2	12
88	Арван долдугаар бүлэг	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	17.1.1, 17.1.2.1, 17.1.2.2, 17.1.2.3, 17.2.1, 17.3.1, 17.4.1, 17.5.1, 17.5.1, 17.7.1, 17.8.1, 17.8.2, 17.9.1, 17.10.1, 17.11.1, 17.11.2, 17.12.1	16
99	Арван наймдугаар бүлэг	Эдийн засгийн гэмт хэрэг	18.1.1, 18.2.1, 18.3.1, 18.4.1, 18.4.2.2, 18.5.1, 18.5.2.2, 18.6.1, 18.6.2.1, 18.6.2.2, 18.6.2.3, 18.8.1, 18.9.1, 18.10.1, 18.10.2, 18.11.1, 18.12.1, 18.14.1, 18.15.1, 18.15.2.1, 18.15.2.2, 18.15.2.3, 18.16.1, 18.16.2.2, 18.17.1, 18.17.2.2,	26
110	Арван есдүгээр бүлэг	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19.8.1, 19.11.1, 19.12.1, 19.13.1, 19.14.1, 19.14.2.1, 19.14.2.2, 19.15.1, 19.15.2, 19.16.1, 19.17.1	11
111	Хорьдугаар бүлэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	20.4.1, 20.5.1, 20.6.1, 20.7.1, 20.8.1, 20.9.1, 20.10.1, 20.11.1, 20.12.1, 20.13.1, 20.14.1, 20.14.2, 20.15.1, 20.16.1, 20.17.1, 20.17.2	16
112	Хорин нэгдүгээр бүлэг	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	21.1.2, 21.2.1, 21.2.2, 21.3.1, 21.4.1, 21.5.1, 21.5.2, 21.6.1, 21.7.1, 21.8.1, 21.9.1, 21.9.2, 21.10.1, 21.10.2, 21.14.1, 21.14.2	16
113	Хорин хоёрдугаар бүлэг	Авлигын гэмт хэрэг	22.1.1, 22.1.2, 22.3.1, 22.4.1, 22.4.2, 22.4.3, 22.5.1, 22.5.2, 22.6.1, 22.6.2, 22.7.1, 22.1.8.1, 22.8.1.1, 22.8.1.2, 22.8.1.3, 22.8.1.4, 22.8.1.5, 22.8.1.6, 22.9.1.4, 22.10.1, 22.10.2, 22.11.1, 22.12.1,	26
114	Хорин гуравдугаар бүлэг	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	23.1.1, 23.2.1, 23.1.2.2, 23.3.1, 23.2.2, 23.4.1, 23.4.2, 23.5.1, 23.6.1, 23.7.1,	11
115	Хорин дөрөвдүгээр бүлэг	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	24.1.1, 24.3.1, 24.5.1, 24.6.1, 24.6.2.1, 24.6.2.2, 24.6.2.3, 24.6.2.4, 24.8.1	9
116	Хорин тавдугаар бүлэг	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.2.1, 25.2.2, 25.3.1, 25.4.1, 25.4.2, 25.5.1, 25.6.1	10
117	Хорин зургаадугаар бүлэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	26.1.1, 26.1.2, 26.2.1, 26.3.1	4

118	Хорин долоодугаар бүлэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	27.1.1, 27.1.3, 27.2.1, 27.3.1, 27.4.1, 27.4.2, 27.5.1, 27.6.1, 27.7.1, 27.10.1, 27.10.2.1, 27.10.2.2, 27.10.2.3, 27.10.3, 27.11.1	15
119	Хорин наймдугаар бүлэг	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	28.7.1	1
	Нийт			240

Дээрх судалгаанаас үзэхэд “зорчих эрхийг хязгаарлах ял” эсхүл “хорих ял”-ын аль нэгийг сонгож хэрэглэхээр ихэвчлэн хүнд гэмт хэрэгт буюу -119 заалтад, хөнгөн гэмт хэрэгт буюу -57 заалтад хүний эрүүл мэндийн халдашгүй дархан байдлын эсрэг болон хүний халдашгүй чөлөөтэй байх, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэгт түлхүү оногдуулахаар хуульчилсан байна.

Өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрүүгийн хуулиас шинэчлэн батлагдсан эрүүгийн хууль нь санкцийн хувьд гэмт үйлдэлд оногдуулах ялын тоо цөөрсөн ч ял шийтгэл оногдуулах гэмт үйлдлийн тоо – 230 буюу 26 хувиар, гэмт хэрэгт оногдуулах хорихоос өөр төрлийн ялын тоон үзүүлэлт – 228 буюу 58 хувиар өссөн байгаа нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх гол хүчин зүйлсийн нэг гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан “Эрүүгийн

хууль”-д нийт 858 гэмт үйлдэлд ял оногдуулахаас – 391 буюу 45.2 хувьд хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар байсан бол шинэчлэн батлагдсан эрүүгийн хуульд 1088 гэмт үйлдэлд ял оногдуулахаас 619 буюу 58.5 хувьд нь хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар зохицуулсан байгаа нь гэмт үйлдэлд хорихоос өөр төрлийн ял оногдуулах магадлал 13.5 хувиар өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

“Эрүүгийн хууль”-д заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд хорихоос өөр төрлийн ял хэрэглэх /оногдуулах/ нийт 619 /санкц/ -аас 267 тохиолдол буюу 43.1 хувьд торгуулийн ял, 240 тохиолдол буюу 38.7 хувьд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр зохицуулсан байна.


Дараагийн дугаарт судлаачийн зүгээс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тус бүр харьцуулалт хийж үзье.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 4 хэсэг, 20 бүлэг, 144 зүйл буюу 1 хэсэг Ерөнхий үндэслэл 1-9 дүгээр зүйл нь 6.2%, 2

дугаар хэсэг Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 10-19 дүгээр зүйл 26.8%, 3 дугаар хэсэг буюу Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх

ажиллагаа 90-131 дүгээр зүйл 27%, 4 дүгээр хэсэг буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан 132-144 зүйл 4.3% эзэлж байжээ.


Зураг 4. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зүйл ангийн харьцуулалт



Харин 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай шинэчилсэн найруулга нь 5 хэсэг, 27 бүлэг, 302 зүйлээс бүрдэж, 1 дүгээр хэсэг буюу ерөнхий үндэслэл нь 1-17 зүйл 5.6%, Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 18-122 дугаар зүйл 34.7%,

3 дугаар хэсэг буюу захиргааны болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 123-152 дугаар зүйл 9.9%, 4 дүгээр хэсэг буюу эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 153-256 дугаар зүйл буюу 34.4%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 5. 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зүйл ангийн харьцуулалт.



Эндээс үзэхэд хуулийн агуулга, бүтэц, зохицуулсан харилцаа 1 дахин өссөнөөс гадна эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 27 хувиас 34.7 хувь буюу 8 орчим хувиар өссөн нь *“зорчих эрхийг хязгаарлах ял”*-ыг шинээр ялын төрөлд нэмсэн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүргийг нэмэгдүүлсэнтэй шууд холбоотой гэж үзэж болохоор байна.

Дүгнэлт

Монгол Улс Их Хурлаар Эрүүгийн хуулийг шинэчлэн батлахдаа шүүхээс гэм буруутай нь тогтоогдсон хүнд хорихоос бусад төрлийн ялыг түлхүү оногдуулахаар хуульчилсан буюу гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах хуулийн санкц 228 буюу өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрүүгийн хуультай харьцуулахад 58 хувиар өссөн нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйл болсон гэж дүгнэж болохоор байна.

Өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны эрүүгийн хуульд нийт 858 гэмт үйлдэлд ял оногдуулахаас – 391 буюу 45.2 хувьд хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар байсан бол шинэчлэн батлагдсан эрүүгийн хуульд 1088 гэмт үйлдэлд ял оногдуулахаас 619 буюу 58.5 хувьд нь хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар зохицуулсан байгаа нь гэмт үйлдэлд хорихоос өөр төрлийн ял оногдуулах магадлал 13.5 хувиар өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

Өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрүүгийн хуулийг одоо хүчин

төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуультай харьцуулахад шинээр батлагдсан эрүүгийн хууль гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хорих бус хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэхээр хуульчилсан нь манай орны эрүүгийн ялын бодлого энэрэнгүй /гуманизация уголовной политики/ ёсны зарчимд суурилсан буюу ялын уян хатан, зөөлөн /гибкость/ бодлогыг баримталж буйг илтгэн харуулж байна.

Түүнчлэн Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэн батлагдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өөртөө мэргэжлийн олон төрлийн албадыг багтааж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл нэмэгдэхийн хирээр үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчинг боловсронгуй болгох, ял эдлүүлэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг тэнцэвржүүлэх ¹ цаг үеийн шаардлага байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Санал

Иймд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг тэнцэвржүүлэх үүднээс “Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал”-аар баталсан “эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал, жишиг норматив”-д заасан “Нийслэлд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид ноогдох 160 гүйцэтгэх хуудас”-ыг

¹ Д.Дамдинцэрэн. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн

шинэтгэл сэдэвт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 9 дэх тал.

“...Нийслэлд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид 100 гүйцэтгэх хуудас ноогдоно...” гэж өөрчлөн найруулах саналтай байна.

Эх сурвалжийн жагсаалт:

Д.Дамдинцэрэн. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 9 дэх тал.

Ч.Болд, Э. Жамбалрагчаа. “Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд

тулгарч буй асуудлууд: Гадаад орны туршлага”. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2018. 159 дахь тал.

Э.Жамбалрагчаа, Э.Урангоо.

“Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 180 дахь тал. ОХУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл 2010. №14. http://www.consultant.ru/document/cons_d oc_LAW_99050/(хандалт-10.01.2018 он)